



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 03 сарын 28 өдөр

Дугаар A/106

Улаанбаатар хот

**Чингэлтэй дүүргийн Иргэдийн
Төлөөлөгчдийн хурлын данс бүртгэлээс
тээврийн хэрэгсэл хасах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/61 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Өмчийн харилцааны газраас 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан тээврийн хэрэгслийн нээлттэй дуудлага худалдаагаар худалдсан 25,000,000 (хорин таван сая) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Тоёото Кроун маркийн 02-55 УБҮ улсын дугаартай тээврийн хэрэгслийг данс бүртгэлээсээ хасахыг Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал (Б.Мөнхбат)-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал (Б.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (П.Магнайбаатар)-т тус тус даалгасугай.

ДАРГА



М. БАЯРАА

115080000293